

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.12.09 - 12.13

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт нь АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрт ахиц гарсантай холбоотой байлаа.

S&P 500 индексийн сагсанд багтах хагас дамжуулагч үйлдвэрлэгч компаниудын хувьцаа АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрээс үүдэн хамгийн их өсөлт үзүүлээ. Мөн, худалдааны хэлэлцээрээс үүдэн газрын тосны үнэ сүүлийн 3 сарын дээд ханшиндаа хүрснээс үүдэн эрчим хүчний компаниудын хувьцаа өсөлттэй байсан бол үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцаа уналттай байлаа.

АНУ-д БНХАУ-аас импортоор орж ирж буй бараа бүтээгдэхүүнүүдэд шинээр ногдуулж буй гаалийн татварууд энэ сарын 15-аас хэрэгжиж эхлэхтэй холбоотой энэ долоо хоногийн эхэн үед хувьцааны ханш хэлбэлзэл ихтэй байсан бол Пүрэв гарагт АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп шинээр хэрэгжиж эхлэх гаалийн татваруудыг хүчингүй болгож мөн одоо хэрэгжиж буй зарим нэг татварыг бууруулахаар болсон тухайгаа мэдэгджээ. Энэхүү үйлдлийн хариуд БНХАУ-аас АНУ-ын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн худалдан авалтыг нэмэхээр болжээ.

**Европ:** Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрт ахиц гарсантай болон Их Британийн Ерөнхий сайд ноён Борис Жонсон болон түүний Консерватив нам сонгуульд ялалт байгуулсантай холбоотой өсөлттэй байлаа.

Их Британийн Консерватив нам нийт 650 суудлаас 364 суудалд ялалт байгуулснаар 79 суудлын илүүтэйгээр олонх болж байгаа юм. Энэ нь Консерватив намын 1987 оноос хойших хамгийн том ялалт болж байгаа юм.

Шинжээчдийн үзэж байгаагаар шинэ Парламент нь Их Британи улсыг Европын холбооноос гарах хэлэлцээрийг бүрэн дэмжих ба Их Британи Европын холбооноос 01-р сарын 31-нд гарвал энэхүү хэлэлцээрийн худалдааны нөхцөлүүд маш чухал юм.

**Япон:** Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээртэй холбоотой өсөлттэй хаагдлаа.

Мөн, Япон улсын засгийн газраас эдийн засгийн өсөлтийн таамагийг 1.8% болгон дээшлүүлжээ. Энэхүү таамаг нь шинжээчдийн таамаглаж буй дундаж дүн болох 0.6%-аас 3 дахин их байгаа ба энэхүү таамаглалын үндэслэл нь хөрөнгө оруулалт болон дотоод хэрэглээ өсөлттэй байгаатай холбоотой юм.

**БНХАУ:** АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны эхний шатны хэлэлцээрийн хүрээнд БНХАУ-ын 160 сая ам долларын бараа бүтээгдэхүүнүүдэд ногдох байсан шинэ гаалийн татвар хүчингүй болсонтой холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Хэдийгээр БНХАУ-ын эрх баригчид энэхүү мэдээллийг бататгаагүй байгаа ч хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд 10-р сараас хойших дээд төвшиндөө хүрчээ.

**Эх сурвалж:** Troweprice.com

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,051.38	1.96% ▲
Dow Jones	АНУ	28,135.38	0.43% ▲
S&P 500	АНУ	3,168.80	0.73% ▲
Nasdaq	АНУ	8,734.88	0.91% ▲
S&P/TSX	Канад	17,003.13	0.04% ▲
FTSE 100	Их Британи	7,353.44	1.57% ▲
S&P/ASX 200	Австрали	6,739.70	0.49% ▲
Nikkei 225	Япон	24,023.10	2.86% ▲
Hang Seng	Хонг Конг	27,687.76	5.61% ▲

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.36
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.20
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.27
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.21
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.26
DBM' 2023	USD	7.250%	105.71
TDBM' 2020	USD	9.375%	102.27
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.39

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.737	0.02 ▲
Libor 3M	1.899	0.01 ▲
Libor 6M	1.902	0.02 ▲
Libor 1YR	1.963	0.04 ▲
US 2YR Bond	1.614	-0.01 ▼
US 3YR Bond	1.633	-0.01 ▼
US 5YR Bond	1.667	0.00 ▲
US 10YR Bond	1.835	0.00 ▼

### Валютын ханш /төг/

Валют	2019.12.13	Өөрчлөлт
USD	2,726.12	0.16% ▲
CNY	390.30	0.82% ▲
EUR	3,047.53	0.81% ▲
RUB	43.59	2.06% ▲
KRW	2.33	1.75% ▲
JPY	24.87	-0.68% ▼
CAD	2,071.99	0.32% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,476.33	1.11% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	16.93	2.15% ▲
Зэс	USD/lb.	278.10	2.06% ▲
Нүүрс	USD/MT	68.33	-0.71% ▼
WTI газрын тос	USD/bbl.	60.07	1.47% ▲
Brent газрын тос	USD/bbl.	65.22	1.29% ▲

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. X	7.60%
Бодлогын хүү	2019. X	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. X	11.06%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. X	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. X	4.82%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. X	16.90%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. X	10.61%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 43 компанийн 333.7 сая төгрөгийн 1,293,792 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Дархан гурил тэжээл” /DAR/ компанийн хувьцаа 32.21%-аар буюу хамгийн ихээр өсөж 2,791.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Стандарт агрикалчер групп” /SOH/ компанийн хувьцаа 16.94%-аар буурч 99.7 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

12-р сарын 16-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,615.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,051.38 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.96%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	333.7
Зах зээлийн үнэлгээ	2,615,395.9

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,051.38	1.96% ▲
MSE I индекс	9,176.12	4.04% ▲
MSE II индекс	7,757.89	1.11% ▲

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	77,828	136,697,070
АПУ	145,406	87,089,743
Сүү	80,473	17,151,948
Ард кредит ББСБ	180,631	13,883,423
Лэндмн ББСБ	277,842	12,010,932

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан гурил тэжээл	2,791.00	32.21% ▲
Материалимпекс	8,300.00	22.06% ▲
Авто импекс	1,550.00	16.98% ▲
Хөдөөгийн тээвэр	4,600.00	15.00% ▲
Ард санхүүгийн нэгдэл	1,899.00	11.12% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Стандарт агрикалчер групп	99.67	-16.94% ▼
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	90.00	-12.20% ▼
Улсын их дэлгүүр	975.00	-11.36% ▼
Махимпекс	2,200.00	-10.17% ▼
Гермес центр	128.92	-3.79% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	271,248,019
Голомт Капитал	116,644,346
Ти Ди Би Капитал	66,194,347
Би Ди Сек	63,243,529
Стандарт Инвестмент	32,467,012

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	608.29	647,331
Таван толгой	6,670.00	351,277
МИК Холдинг	14,000.00	289,930
Говь	255.45	199,930
Инвескор ББСБ	2,172.00	155,793

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Иргэд хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан зах зээлд оролцох эрх зүйн орчин бүрдлээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6-р сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 11-р сарын 13-ны өдрийн 537 тоот тушаалаар батламжилсан билээ. Энэхүү журмыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 12-р сарын 06-ны өдөр зах зээлийн мэргэжлийн оролцогчид болох хөрөнгө оруулалтын менежментийн болон үнэт цаасны компаниудад зориулсан танилцуулга, сургалтыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас зохион байгууллаа.

“Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам” хэрэгжиж эхэлснээр, хөрөнгө оруулалтын сангууд нэгж эрхээ Биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжих, татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэгж эрх эзэмшигчдийн өмнөөс мэргэжлийн удирдлагаар хангаж, хөрөнгийн зах зээлд тодорхой хувийг оруулах, улмаар дотоодын зах зээлд нэн шаардагдаж буй урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулагчид бий болох боломж нээгдэж буй онцгой ач холбогдолтой юм.

Сургалтаар хамтын хаалттай сангийн талаар үндсэн ойлголт, олон улсын практик туршлагаас хуваалцсанаас гадна сан үүсгэн байгуулж СЗХ болон МХБ-д бүртгүүлэх эрх зүйн нөхцөл байдал, бүртгэлтэй байх хугацаанд тогтмол хэрэгжүүлэх үүргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

**Эх сурвалж:** Монголын Хөрөнгийн Бирж

### “АПУ” ХК ОХУ дахь борлуулалтын сүлжээгээ нэмэгдүүлэв

Дотоодын архи, шар айрагны зах зээлийн гол тоглогч “АПУ” ХК /MSE:APU/ эхний ээлжинд экспортын гол зах зээлээ ОХУ болон БНХАУ байх талаар удирдлагуудын зүгээс хувьцаа эзэмшигчидэд тогтмол мэдээлэл өгч байгаа.

Тухайлбал, 11-р сарын эхээр компани ОХУ-ын 17 хотын 200 гаруй цэгүүдээр бүтээгдэхүүнийхээ борлуулалтыг хийж эхэлсэн талаар бид мэдээлсэн. Энэхүү мэдээлэлтэй холбоотойгоор хувьцааны зах зээл дээр 500.1 төгрөг хүртэл буурсан хувьцааны ханш нь 2019.12.13-ны байдлаар 608.3 төгрөг болж 17.08%-аар эргэн өсөв.

Харин өнгөрөгч долоо хоногт “АПУ” ХК /MSE:APU/ нь ОХУ-ын “Татспиртпром” компанитай хамтран ажиллахаар болж, Казань хотод холбогдох гэрээнд гарын үсэг зурснаа мэдэгдлээ.

Гэрээний хүрээнд “Татспиртпром” компани нь АПУ-ийн бүтээгдэхүүнийг өөрийн улсад борлуулах ажлыг хэрэгжүүлэх бол АПУ-ийн зүгээс тус компанийн “Тундра” нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын зах зээлд борлуулах ажээ

**Эх сурвалж:** MarketInfo.mn

### “Говь” ХК ТУЗ-ийн гишүүнийг түр томилов

“Говь” ХК-ийн /MSE:GOV/ ТУЗ-ийн гишүүн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж байгаатай холбоотойгоор шинэ гишүүнийг түр хугацаанд томилсон талаар тус компаниас мэдээлэв.

Тодруулбал, ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Шагдарсүрэн нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж байгаа бөгөөд түүний оронд А.Жаргалмааг түр томилох шийдвэрийг ТУЗ-өөс гаргасан байна.

**Эх сурвалж:** MarketInfo.mn



### “Эрдэнэ ресурс девелопмент корпораци” ХК нь Баян Хөндий алтны төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг бүртгүүлж, Европын сэргээн босголт хөгжлийн банкны оролцоотой хийсэн санхүүжилтийг хаалаа

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус техникийн тайланг SEDAR (“System for electronic document analysis and retrieval”)–т бүртгүүлснийг зарлаж байна. Энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ” буюу “PFS”) болон Баян Хөндийгөөс 16 км зайд орших Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Тайланг Tetra Tech Inc (“Tetra Tech”) NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын (“NI 43-101”) дагуу боловсруулж, Хөндий Алтны Төслийн NI 43-101 Техникийн Тайлан (“Khundii Gold Project Ni 43-101 Technical Report”) нэртэйгээр 2019 оны 12-р сарын 04-нд бүртгүүллээ. Тайлантай [www.sedar.com](http://www.sedar.com) дахь компанийн хуудас болон компанийн [www.erdene.com](http://www.erdene.com) вебсайтаас танилцах боломжтой.

Компани нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“the European Bank for Reconstruction and Development”) буюу “ЕСБХБ”)–ны оролцоотой санхүүжилтийн багцыг танилцуулж байсан. Дээрх санхүүжилттэй холбоотойгоор ЕСБХБ-аас 5 сая америк доллар (6.6 сая канад доллар), мөн 1 сая канад долларын зуучлалгүй хаалттай санхүүжилтийн орлогыг хүлээн авсныг мэдээлэлж байна. Санхүүжилт нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”)–ийг хараат бус эцсийн ТЭЗҮ (“FS”), анхан шатны инженерийн загварчлал (“FEED”), хайгуул болон хөрөнгө оруулалтын зардлууд, эргэлтийн хөрөнгөд зарцуулагдана.

**Эх сурвалж:** Erdene.com

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Оюу толгойчууд гүний уурхайн Үйлдвэрлэлийн амаа барьж дууслаа

Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын нэн чухал амжилт болох Үйлдвэрлэлийн амыг барьж дууссаныг өнөөдөр тэмдэглэн өнгөрүүлээ.

Дэлхийд хэмжээгээрээ тэргүүлэх, хамгийн орчин үеийн гүний уурхайн ам болох тус Үйлдвэрлэлийн амны барилгын ажил амжилттай дууссантай холбогдуулан хийсэн ёслолын ажиллагаанд уг бүтээн байгуулалтад гар бие оролцсон үндэсний компаниуд, уурхайчид болон албаны бусад зочид төлөөлөгчид оролцлоо.

“Оюу толгой” компанийн ТУЗ-ийн дарга, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Галсангийн Батсүх ёслолын ажиллагааны нээлтэд хэлсэн үгэндээ, гүний уурхайн энэхүү Үйлдвэрийн амыг амжилттай барьж дуусгахад манай улсын төр, засгийн газрын байгууллагуудын дэмжлэг чухал ач холбогдолтой байсныг онцлон тэмдэглэв. Мөн түүнчлэн “Энэхүү томоохон бүтээн байгуулалт нь манай орны уул уурхайн салбар, технологийн хөгжил, дэвшилд ихээхэн хувь нэмэр оруулж байна” гэлээ.

“Үйлдвэрлэлийн амны уулын нэвтрэлтээс эхлээд газрын гүнд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг байрлуулах, барилгын нүсэр бүтээн байгуулалтын ажлыг дуусгахад нийт гурван жил дөрвөн сарын хугацаа орлоо. Оюу толгойн гүний уурхайг бүрэн цогцлоох гол алхам болох ийм чухал хийгээд нарийн дэд бүтцийг барьж дуусгахад үндэсний 50 орчим компанийн 2,500 хүн 2.6 сая цаг аюул ослоос ангид ажиллалаа” хэмээн “Оюу толгой” компанийн Гүйцэтгэх захирал Армандо Торрес хэллээ.

Мянга хоёр зуун наян дөрвөн (1,284) метрийн гүн бүхий үйлдвэрлэлийн үндсэн амаар хүн болон ачаа тээвэрлэж, мөн хүдрийн чулуулгийг газрын гадарга руу гаргана. Үйлдвэрлэлийн амны бүтээгдэхүүн тээвэрлэх өргүүр нь дэлхийд томдоо орох “Коепе” (үрэлтийн хүчний өргүүр) ган татлагат өргүүрийн системтэй. Уг өргүүрийн 60 тонны даацтай ачаа тээвэрлэх хоёр хөнөг 59 км/цаг буюу хамгийн дээд хурдаараа өдөрт 28,000 тонн хүдэр тээвэрлэх хүчин чадалтай. Үйлчилгээний амны хөнөг нэг удаадаа 60 хүн тээвэрлэх хүчин чадалтай бол Үйлдвэрлэлийн амаар нэг дор 300 хүн тээвэрлэх боломжтой юм. Үйлдвэрлэлийн амны өргүүрийн ган татлага суурилуулах ажилд 500 орчим хүн оролцож, 23 хоногийг зарцуулсан нь энэ төрлийн ажлуудаас дэлхийд хамгийн өндөр бүтээмжтэй, аюулгүй хийсэн угсралтын ажил болсон байна.

### Гүний уурхайн төсөлд Үйлдвэрлэлийн амны гүйцэтгэх үүрэг

Туршилт тохируулгын ажил амжилттай дуусаж, холбогдох зөвшөөрлүүдийг авснаар Үйлдвэрлэлийн ам бүрэн ашиглалтад орно. Ингэснээр гүний уурхайн бүтээн байгуулалтад дараах ахиц гарна.

- Илүү олон хүн, материал, тоног төхөөрөмжийг гүний уурхай руу тээвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг түргэсгэнэ.
- Илүү их хэмжээний чулуулгийг гүний уурхайгаас гаргаж, хүдрийн биетэд нэвтрэх боломжийг ахиулна

Иймд гүний уурхайд ажиллах хүмүүсийн тоо Үйлчилгээний амны хүн тээвэрлэх хөнөгийн хүчин чадлаар хязгаарлагддаг байсан нь одоо ашиглагдаж буй болон баригдаад байгаа уурхайн амнуудаар (Үйлчилгээний, Үйлдвэрийн болон агааржуулалтын дунд ам) орж ирж буй агаарын хэмжээнээс шалтгаалах юм. Агааржуулалтыг нэмэлт хоёр ам буюу урд (агаарыг оруулах) болон хойд амны (агаарыг гаргах) бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Одоогийн байдлаар гүний уурхайн нэг ээлжид 700 хүн ажиллах боломжтой юм.

### Нэмэлт мэдээлэл:

- Үйлдвэрлэлийн амны хэмжээ: Нийт 1,300 метр (цамхгийн барилга нь 96 метр, газрын гүн рүү 1,284 метр) байгууламж (нийт өндрөөрөө Улаанбаатар дахь Шангри-Ла барилгыг 15 давхарласантай тэнцэнэ. Өөрөөр хэлбэл газрын гүнд 14-ийг, гадаргаас дээш нэгийг давхарласантай тэнцэнэ). Дотор голч нь 10 метр.
- Үйлдвэрлэлийн амны цамхгийн барилга нь АНУ-ын “Эрх чөлөөний хөшөө”-тэй (суурийн тавцангаас галт бамбарын дээд үзүүр хүртэл 92 метр) ойролцоо өндөртэй.
- Үйлдвэрлэлийн амны бүтээгдэхүүн тээвэрлэх өргүүр нь дэлхийд хамгийн томд тооцогдох “Коепе” (үрэлтийн хүчний өргүүр) ган татлагат өргүүрийн систем юм
- Дэлхийн хамгийн том “Коепе” ороогч дамар хоёр ширхэг
- 32 км (ойролцоогоор ОТ уурхайн цогцолбороос Ханбогд сум хүрэх зай) урт ган татлагаас бүрддэг
- Үйлдвэрлэлийн амны бүтээгдэхүүний өргүүр нь дэлхийд хамгийн томд тооцогдох “Коепе” (үрэлтийн хүчний өргүүр) ган татлагат өргүүрийн системтэй.
- Үйлчилгээний өргүүр: Нэг удаад 300 хүнийг (хүн тээврийн хөнөгийн дээд багтаамж) тээвэрлэх боломжтой ба 1.3 км-ийн гүнд очиход ердөө хоёр минут хагас хугацаа зарцуулна. Хоногт ойролцоогоор 2,400 орчим зорчигчийг тээвэрлэх хүчин чадалтай. Хөнөг 10 м/секундэд 48 тонн тээвэрлэх даацтай.
- Бүтээгдэхүүний өргүүр: 60 тонны даацтай хоёр ширхэг хөнөг хоногт 28,000 тонн хүдрийг 16.38 м/сек (59 км/цаг) дээд хурдтайгаар тээвэрлэнэ.

Оюу толгойн гүний уурхай нийт таван амтай. Одоогоор үйлчилгээний амыг ашиглан гүний уурхайн төслийн талбайруу хүн болон материал тээвэрлэж байна. Агааржуулалтын урд болон хойд амны барилгын ажил тус бүр 1,148 метр болон 1,149 метрийн гүнд үргэлжилж байна. Энэ хоёр ам (агаарыг оруулах, гаргах) гүний уурхайн үйл ажиллагааны хугацаанд нэмэлт агааржуулалтаар хангах үүрэгтэй. Одоо ашиглаж буй 1,174 метрийн гүн бүхий Агааржуулалтын дунд ам агааржуулалтыг хоёр дахин нэмэгдүүлсэн. Ингэснээр хөндлөн нэвтрэлт болон уурхайн барилгын явц дахь хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлээд байна. Түүнчлэн “Чандмань” гүний уурхайн захиргаа үйлчилгээний төв энэ оны наймдугаар сард ашиглалтад орсон. Гүний уурхайн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, хяналтын энэхүү төв нь хяналтын өрөө, ажилчдын хувцас солих, угаах газар, уулзалтын болон оффисын өрөөтэй.

**Эх сурвалж:** OT.mn

## БУСАД МЭДЭЭ

### Монгол улсын эдийн засгийн 2019 оны 11-р сарын байдал

#### Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 11-р сарын эцэст 20.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 24.2 (0.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.8 (9.6%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 11-р сарын эцэст 860.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 13.7 (1.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 34.9 (3.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 11-р сарын эцэст 18.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 34.1 (0.2%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.4 (8.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 11-р сарын эцэст 968.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 16.0 (1.7%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 5.5 (0.6%) тэрбум төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.3 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 11-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 10.8 (0.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 149.1 (7.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр буурсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2019 оны 11-р сард 42.38 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар, өмнөх сараас 1.8 хувиар суларсан байна.

#### Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 9.7 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 9.2 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 486.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 11-р сард 842.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 252.0 (23.0%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 901.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 132.5 (12.8%) тэрбум төгрөгөөр буурчээ

#### Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 тэрбум америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 394.6 сая америк доллараар буурчээ.

Урсгал данс 1.2 тэрбум америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.3 тэрбум америк доллар, анхдагч орлогын данс 1.2 тэрбум америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна

Хөрөнгийн данс 2019 оны эхний 10 сард 77.7 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 1.0 (1.4%) сая америк доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 1.6 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 112.0 (6.7%) сая америк доллараар буурчээ.

Төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 10 сард 51.2 сая америк долларын алдагдалтай байсан бол 2019 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс 304.0 сая америк доллараар өсөж, 252.8 сая америк долларын ашигтай гарчээ.

#### Гадаад худалдаа

Монгол Улс 2019 оны эхний 11 сард дэлхийн 150 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.6 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.1 тэрбум америк доллар, импорт 5.6 тэрбум америк доллар боллоо. Харин 2019 оны 11-р сард экспорт 526.9 сая америк долларт, импорт 519.3 сая америк доллар болж, өмнөх сараас экспорт 55.7 сая америк доллараар буурч, импорт 53.5 сая америк доллараар өсжээ.

#### Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.4 хувиар буурсан бол өмнөх оны эцсээс 4.6 хувь, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11-р сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.5 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 21.9 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.2 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 2.9 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Эх сурвалж:** Erdene.com

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.